ЗАХИРГААНЫ ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ ПРОЦЕСС 2

LEGALINFO.MN АППЛИКЕЙШН APP STORE БОЛОН PLAY STORE ДЭЭР ХЭВИЙН АЖИЛЛАЖ ЭХЭЛЛЭЭ 6

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БАЙЖ ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ 7

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

*Баталсан хууль нь хүн бүрт тэгш үйлчилдэг төр л хамгийн тогтвортой оршдог.*

*Аристотель*

# ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ

www.nli.gov.mn Цахим сонин 2024.02.29

## ХЗҮХ-ИЙН АЛБАН ХААГЧИД АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын тушаалаар Баримт бичиг нягтлан шалгах комиссыг шинэчлэн баталсан. Энэ хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн нийт албан хаагчид 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад хамрагдлаа.

Сургалтаар:

- -Байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комиссын арга зүй;
- -Байгууллагын архивын зохион байгуулалт, арга зүй зэрэгт суралцав.

Сургалтыг Архивын ерөнхий газрын Мэргэжил арга зүйн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн С.Пүрэвсүрэн орлоо.




ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ

Улсын бүртгэлийн дугаар 1197

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Эко Интернэйшнл трэйд тауэр барилгын 9 давхар, Хууль зүйн үндэсний хүрээлэн.

11-315789

www.nli.gov.mn

Бэлтгэсэн: Ц.Энхжин

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

legalinfo.mn

# ЗАХИРГААНЫ ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ



*Swipe*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

legalinfo.mn

**1**

## Дараах тохиолдолд гэрлэлтийг захиргааны журмаар цуцлана

1. Гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн
2. 18 хүртэлх насны хүүхэдгүй
3. Эд хөрөнгийн маргаангүй

ЗАХИРГААНЫ ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

legalinfo.mn

**2**

## Хүсэлт бичих

Гэрлэгчид тус тусдаа гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй гэдгээ илэрхийлсэн хүсэлт бичиж гарын үсгээр баталгаажуулна.

ЗАХИРГААНЫ ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

legalinfo.mn

ЗАХИРГААНЫ ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ

## Хүсэлтэд хавсаргах баримт бичиг

1. Эхнэр, нөхрийн иргэний үнэмлэх, гадаадад оршин суугаа бол гадаад паспорт
2. 18-аас доош насны хүүхэдгүй тухай тодорхойлолт /албан бичгээр/
3. Гэрлэлтийн гэрчилгээ /эх хувиар/, эсвэл гэрлэлтийн лавлагаа

**!**

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

legalinfo.mn

**3**

## Хүсэлтийг хаана гаргах вэ?

1. Гарын үсэг зурсан хүсэлтээ улсын бүртгэлийн байгууллагад гаргана
2. Эсвэл хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газарт гаргана

ЗАХИРГААНЫ ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

legalinfo.mn

ЗАХИРГААНЫ ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ

## Улсын бүртгэл эсвэл дипломат төлөөлөгчийн газарт хүсэлтээ өгөхдөө анхаарах зүйлс

1. Захиргааны журмаар гэрлэлт цуцлуулахад эхнэр, нөхөр хоёр биечлэн байх шаардлагатай
2. Хэрэв эхнэр, нөхрийн хэн нэг нь нас барсан, эрх зүйн чадамжгүйд тооцсон, 3-аас дээш жил хорих ял эдлэхээр таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол хэн нэгний нь гаргасан хүсэлтээр гэрлэлтийг цуцалж болно
3. Үйлчилгээний хураамж тушаана

**!**


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
legalinfo.mn
4
Хугацаа
Улсын бүртгэлийн байгууллага, хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар хүсэлтийг хянан үзэж 30 хоногийн дотор гэрлэлтийг цуцалж болно.
ЗАХИРГААНЫ ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
legalinfo.mn
5
Гэрлэлт дуусгавар болох
Улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтан баримт бичигйиг хүлээн авснаас хойш ажлын 21 өдрийн дотор гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийг хөтөлнө.
ЗАХИРГААНЫ ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
legalinfo.mn
ШҮҮХИЙН ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
legalinfo.mn
1
Дараах тохиолдолд гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлана
1. Гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрөөгүй
2. 18 хүртэлх насны хүүхэдтэй
3. Эд хөрөнгийн маргаантай
4. Гэрлэгчид эрх зүйн чадамжгүй
ШҮҮХИЙН ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
legalinfo.mn
2
Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа
1. 30 хоног
2. Шаардлагатай тохиолдолд 30 хоногоор 1 удаа сунгаж болно.
Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах шаардлагагүй тохиолдол
Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон
ШҮҮХИЙН ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
legalinfo.mn
3
Хугацаа
Эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар 3 сар хүртэл хугацаанд үргэлжлүүлэн, Гэрлэгчид эвлэрэх боломжгүй бол шүүх гэрлэлтийг цуцлана.
ШҮҮХИЙН ЖУРМААР ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
legalinfo.mn
4
Шүүхэд нэхэмжлэл гаргах
Нэхэмжлэлийн агуулга
1. Гэрлэгчдийн ургийн овог, эцгийн нэр, нэр
2. Гэрлэлтээ хэзээ, хаана бүртгүүлсэн, гэрлэлт цуцлуулах шалтгаан, насанд хүрээгүй хүүхэдтэй бол түүний нэр, төрсөн он, сар, өдөр, түүнчлэн насанд хүрээгүй хүүхдийг хүмүүжүүлэх, түүнд асрамж тогтоох, тэжээн тэтгэх болон эд хөрөнгийн талаархи хүсэлт, энэ талаар хоорондоо хэлэлцэн тохиролцсон гэрээ байгаа эсэхийг заах, холбогдох нотлох баримтыг хавсаргана
ШҮҮХИЙН ЖУРМААР
ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
legalinfo.mn
Нэхэмжлэлд хавсаргах материал
1. Нэхэмжлэл 2 хувь
2. Улсын тэмдэгтийн хураамж тушаасан баримт /КИОСК машин /
3. Гэрлэлтийн баталгаа нотариатаар батлуулсан байна
4. Хүүхдийн төрсний гэрчилгээ /нотариат/
5. Нэхэмжлэл гаргаж буй хүний хорооны тодорхойлолт
6. Хүүхэд эсэн мэнд бойжиж буй өрхийн эмнэлгийн тодорхойлолт
7.Хүүхдийн сургуулийн тодорхойлолт
8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болгосон тухай тэмдэглэл
ШҮҮХИЙН ЖУРМААР
ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
legalinfo.mn
5
Нэхэмжлэл гаргах шүүхийн харьяалал
1. Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.
2. Нэхэмжлэгч бага насны хүүхэдтэй буюу тахир дутуу, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хариуцагчийн байгаа газар очиход бэрхшээлтэй байвал нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.
ШҮҮХИЙН ЖУРМААР
ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
legalinfo.mn
6
Гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулсан иргэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ:
Улсын бүртгэлд бүртгүүлэхдээ бүрдүүлэх материал
1. Иргэний үнэмлэх
2. Гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэр
ШҮҮХИЙН ЖУРМААР
ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
legalinfo.mn
7
Улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 1 өдрийн дотор гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийг хөтөлнө.
ШҮҮХИЙН ЖУРМААР
ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ

# ГУРАВДУГААР ДУГААР САРД ЮУ БОЛСОН БЭ?

## 03 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫГ ТЭГЛЭХ ӨДӨР ТОХИОВ

*“Хүн бүрийн эрүүл мэндийг хамгаалъя, хүн бүрийн эрхийг хамгаалъя” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэв.*




## 03 ДУГААР САРЫН 08-НИЙ ӨДӨР ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН ӨДӨР ТОХИОВ

*Анх 1910 онд олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг бий болгох санаачлагыг Германы социалист үзэлтэй эмэгтэй Клара Цеткин гаргасан гэж үздэг. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг өмнө нь олон улсын ажилчин эмэгтэйчүүдийн өдөр хэмээн нэрлэдэг байжээ.*




## ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ АЯНД ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН НЭГДЭВ

*Монгол Улсын Засгийн газар Жендэрийн үндэсний хорооноос жил бүр зохион байгуулдаг үндэсний хэмжээний “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ” нэг сарын аян өрнүүлж байна.*
*Тус аян нь жендэр, жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, сайн туршлага, санаачилгыг түгээн дэлгэрүүлэх зорилготой юм.*




## 03 ДУГААР САРЫН 18-НИЙ ӨДӨР МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР ТОХИОВ



## 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР АРЬС ҮНДСЭЭР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ЯВДЛЫГ УСТГАХ ОЛОН УЛСЫН ӨДӨР ТОХИОВ




## 03 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР НАУРЫЗЫН БАЯР, ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР, МОНГОЛ ХҮН САНСАРТ НИССЭН ТҮҮХЭН ӨДӨР ТУС ТУС ТОХИОВ




## LEGALINFO.MN АППЛИКЕЙШН APP STORE БОЛОН PLAY STORE ДЭЭР ХЭВИЙН АЖИЛЛАЖ ЭХЭЛЛЭЭ






## ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БАЙЖ ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ















# НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

## СЕКТОРЫН ЭРХЛЭГЧ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Ажлын байранд тавигдах ерөнхий шалгуур:

- Хуульч мэргэжилтэй;
- Хууль зүйн ухааны докторын зэрэгтэй;
- Хувийн болон нийтийн эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэшсэн;
- Хууль зүйн судалгааны чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
- 1 гадаад хэлний ахисан түвшний мэдлэгтэй.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл;
- Дипломын хуулбар;
- Бүтээлийн жагсаалт;
- Төрийн албан хаагчийн анкет;
- 3х4 хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- Хувь хүний намтар;
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.

Гүйцэтгэх үүрэг:
Хууль зүйн сургалт, судалгааны төвийн секторын үйл ажиллагааг удирдах, хууль зүйн болон нийгмийн ухааны тодорхой салбараар ахисан түвшний хавсарга болон суурь судалгаа хийх ажлыг удирдан зохион байгуулах, судлаачдыг мэргэжил-арга зүйн зөвлөгөөгөөр хангах.

Бүртгэл: Сонирхсон этгээд бүрдүүлсэн материалаа info@legalinstitute.mn цахим хаягаар ирүүлнэ үү.
Утас: 11-315735

nli.gov.mn

## АРГА ЗҮЙЧ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Ажлын байранд тавигдах ерөнхий шалгуур:

- Эрх зүйч эсвэл багш мэргэжилтэй
- Магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
- Заах арга зүйгээр мэргэшсэн;
- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл;
- Дипломын хуулбар;
- Төрийн албан хаагчийн анкет;
- 3х4 хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- Хувь хүний намтар;
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.

Гүйцэтгэх үүрэг:
Сургалтын хөтөлбөр боловсруулах, хичээлийн үр дүнд үнэлгээ өгөх, сургагч багш нарт заах арга зүйн туслалцаа үзүүлэх, төлөвлөгөөт болон захиалгат сургалтын ажилд хяналт тавих, хариуцах, сургалтад хичээл заах.

Бүртгэл: Сонирхсон этгээд бүрдүүлсэн материалаа info@legalinstitute.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Утас: 11-315735

nli.gov.mn

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Ажлын байранд тавигдах ерөнхий шалгуур:

- Эрх зүйч эсвэл социологич мэргэжилтэй;
- Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
- 1-ээс доошгүй жил судалгаа хийсэн туршлагатай;
- Англи хэл болон бусад хэлээр ахисан түвшний мэдлэгтэй бол давуу талтай.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл;
- Дипломын хуулбар;
- Төрийн албан хаагчийн анкет;
- 3х4 хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- Хувь хүний намтар;
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.

Гүйцэтгэх үүрэг:
Хууль зүйн болон нийгмийн ухааны тодорхой салбараар ахисан түвшний хавсарга болон суурь судалгааг шинжлэх ухааны арга зүйн дагуу хийж гүйцэтгэх, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, сургалт, семинар зохион байгуулах.

Бүртгэл: Сонирхсон этгээд бүрдүүлсэн материалаа info@legalinstitute.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Утас: 11-315735

nli.gov.mn

## ПРОГРАММИСТ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Ажлын байранд тавигдах шаардлага:
- Боловсрол: Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
- Мэргэжил: Мэдээлэл технологийн мэргэжилтэн;
- Туршлага: Мэргэжлээрээ 1-с доошгүй жил ажилласан байх;
- Ур чадвар: Багаар ажиллах чадвартай, хариуцлагатай.

Бүрдүүлэх материал:
- Ажилд орохыг хүссэн өргөдөл;
- Боловсролын диплом болон тэдгээртэй адилтгах баримт бичгийн хуулбар;
- Төрийн албан хаагчийн анкет;
- 3*4 хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- Хувь хүний намтар;
- Иргэний үнэмлэхний хуулбар.

Бүртгэл: Сонирхсон этгээд бүрдүүлсэн материалаа info@legalinstitute.mn цахим хаягаар ирүүлнэ үү.
Утас: 11-315735

nli.gov.mn